



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/11

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1,17, 66 дугаар зүйлийн 66.1 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.4, дахь заалт, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар ээлжийн хурлаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнүүдийн төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 18,500,000 (Арван найман сая таван зуун мянга) төгрөгийг Сумын орон нутгийн хөгжлийн сангийн "Гамшгаас хамгаалах зардал"-аас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын дарга (В.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.АНХБАЯР

Сумын Засаг даргын 2023 оны
24 дүгээр сарын 06 өдрийн 24 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

Гамшгаас хамгаалах зардал 18,500.00 төгрөгийн задаргаа

№	Зарцуулах төрөл	Үнэ
1.	Утасны төлбөр	960.0
2.	Бичиг хэрэг	2,000.0
3.	Ариутгал халдваргүйжүүлэлт	3,000.0
4.	Халдвар хамгаалал	1,000.0
5.	Витаминжуулалт	1,000.0
6.	Байгалийн давтагдашгүй аюул ослын үед зарцуулагдах зардал	4,000.0
7.	Сэг зэм булшлах, эрэн хайж устгах	6,540.0
8.	Бүгд	18,500.0



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 4/12

Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн
хүүгийн орлого зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, ХХААХҮСайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам"-ын 2.7 дах заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 50 хүртэл хувийг хууль тогтоомжид нийцүүлэн захирамжийн хавсралтын дагуу зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан хүүгийн орлого 2800000 / хоёр сая найман зуун мянга / төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас зарцуулахыг Нягтлан бодогч / Б.Солонгомаа /-д зөвшөөрсүгэй

3. Сангийн зээлийн хүүгийн орлогын зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын хорооны дарга / Х.Мөнхбаатар /-т үүрэг болгосугай



Г.АНХБАЯР

Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын
06-ны өдрийн 12 дугаар захирамжийн 1... р хавсралт

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогын
Зарцуулалт

№	Зардлын ангилал	Мөнгөн дүн
1	Сургалт сурталчилгаа	840000
2	Программ хангамж	460000
3	Төслийн үр дүн, хяналт шалгалт	600000
4	Хоршоо хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн болон ажлын хэсгийнхэний урамшуулал	900000
5	Нийт / төгрөг /	2800000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 4/13

Баянтал сум

Хүүхэд хамгаалах баг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/239, 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/476 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтал сумын Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх хүүхэд хамгааллын багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн дарга:

Д.Цэрэнням

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Гишүүд:

О.Жамъяншарав

(Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан)

А.Норовсүрэн

(Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш)

Г.Энх-Амгалан

(Ерөнхий боловсролын сургуулийн эмч)

Нарийн бичгийн дарга:

Б.Батцэцэг

(Баянтал сумын Дотуур байрны багш)

2.Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хамгаалж, боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэхэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, журмын дагуу ажиллахыг комиссын дарга гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/37 дугаар захирамжийг хүчингүйд тооцоссугай.

ДАРГА

Г.АНХБАЯР



ДӨНСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 4/14

Баянтал сум

2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 21.4.3, 23 дугаар зүйлийн 23.4.1, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Э.Эрхэмбаатар - Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Т.Эрдэнэбаяр – ХАА-н мэргэжилтэн

Э.Түмэн-Эрдэнэ -1 дүгээр багийн Засаг дарга

Т.Ган-Эрдэнэ - 2 дугаар багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Ц.Загарсүрэн - Газрын даамал

2. 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр газрыг эзэмших, ашиглах хамгаалах саналыг иргэн, аж ахуй нэгж байгууллагаас авч ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох хууль журамын дагуу чанартай зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3. 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар ирсэн саналыг улирал бүр ажлын хэсгээр хэлэлцүүлж иргэдэд хариу мэдэгдэж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

4. 2024 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн нэгтгэлийг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим системд бүрэн, оруулж хяналтын төлөвт шилжүүлэн холбогдох газраас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажиллахыг, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ц.Загарсүрэн)-д даалгасугай.

ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 4/15

Баянтал сум

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дах заалтыг тус тус үндэслэн Захирамжлах нь:

1. Сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2005 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 36 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дугаарт бүртгэгдсэн гэр бүлийн хамтын хэрэгцээнний зориулалтаар өмчилсөн иргэн Дагвадорж овогтой Батцэнгэл (РД: ЕЙ57030511)-т шинэчилсэн хаягаар Баянтал сумын 1 дүгээр баг Сүлд-8 гудамжны 833 тоот хаягт 0.4996 га /4996м.кв/ газрын шийдвэрт өөрчлөлт оруулсугай.
2. Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэнд үүрэг болгосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР



ТӨВБСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/16

Баянтал сум

Газар эзэмших эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 46.1 дэх заалтуудыг үндэслэн Захирамжлах нь:

1. Гранд флюорит ХХК нь тус сумын 1 дүгээр багийн Хүдрийн үйлдвэрийн урд талд байршилтай үйлдвэрлэлийн зориулалтай 4.27 га (42700м²) газрын газар эзэмших эрхийг сэргээх хүсэлт гаргасан тул сум Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/67 дугаар тоот захирамжийг хүчинтэйд тооцож, анх авсан хугацаагаар эзэмших эрхийг сэргээсүгэй.

2. Хуулийн дагуу эзэмшиж байсан газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшихийг Гранд флюорит ХХК-ний захирал (М.Төрмөнх)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/49 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

- Г.АНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ
БАНСЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛЖ
ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХЫГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА (В.ГАНТУЯА)-Д
ДААЛГАСУГАЙ.

2023

02

13

А/17

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 4.1, 4.2 тус тус үндэслэн Захирамжлах нь:

1. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах 2.341.270 / хоёр сая гурван зуун дөчин нэгэн мянга хоёр зуун дал/ төгрөгний зардлын задаргааг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Тус зардлыг 2023 оны Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.
3. Тус ажлын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР

Сумын Засаг даргын 2023 оны
44 дугаар сарын 13 өдрийн 17 дугаар
Захирамжийн 1 дүгээр
хавсралт

УЛСЫН АВАРГА, АЙМГИЙН АВАРГА, АЛДАРТ УЯАЧ,
СУМЫН АВАРГА, МЯНГАТ МАЛЧДЫН ШАГНАЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжиж нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Агар хувин /жигжиг/	ш	3	90,000	270,000
2	Агар хувин том	ш	1	320,000	320,000
3	Цацлын халбага	ш	1	110,000	110,000
4	Домбо	ш	2	190,000	380,000
5	Морин хуур	ш	1	420,000	420,000
6	Сүү	ш	8	4,800	38,400
7	Чихэр	хайрцаг	9	15,325	130,600
8	Төв талбайн гацуур модны чимэглэл	хайрцаг	хайрцаг	372,270	372,270
9	Цасны баярын арга хэмжээ			300,000	300,000
	Нийт				2.341.270

Төсвийн тооцоолол гаргасан нярав

Н.Сарантуяа



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/18.

Баянтал сум

Сумын алдарт уяач цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ийн "а" Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн баяр наадмын хурдан морины уралдаанд уясан морь нь 5 удаа айрагдаж сумын баяр наадамд 3 удаа түрүүлж, 7 удаа айрагдсан Бямбасүрэн овогтой Ширчинжав, Аймгийн баяр наадамд 6 удаа айрагдаж, сумын баяр наадамд 2 удаа түрүүлж, 10 удаа айрагдсан тул Баатархүү овогтой Наранбаясгалан нарт сумын Алдарт уяач цол олгосугай.

2. Алдарт уяач цолны тэмдэг үнэмлэхийг олгохыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 4/19

Баянтал сум

Газар эзэмших эрхийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Тус сумын 2-р баг Хатуу хучилтай автозамын баруун урд талд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй иргэн Хүүхнээгийн Мөнхбаатарын (ЗЮ66021833), 4203002101 тоот нэгж талбарын дугаар бүхий 1200м² газрын газар эзэмших эрхийн хугацааг 15 жилийн хугацаатайгаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхээ сунгуулсан иргэн Х.Мөнхбаатарын газар эзэмших гэрээг шинээр байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, ажиллахыг сумын Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 4/20

Баянтал сум

Газар эзэмших эрхийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Тус сумын 1-р баг Хагуу хучилтай автозамын зүүн талд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй иргэн Ишдоржийн Доржсүрэнгийн (ЗН59030111), 4203002155 тоот нэгж талбарын дугаар бүхий 1200м² газрын газар эзэмших эрхийн хугацааг 15 жилийн хугацаатайгаар сунгаж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхээ сунгуулсан иргэн И.Доржсүрэнгийн газар эзэмших гэрээг шинээр байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, ажиллахыг сумын Газрын даамал (Ц.Загасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 4/21

Баянтал сум

Хүүхэд хамгаалах баг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол улсын бөгсвсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/476 дугаар тушаал, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 3 дугаар тогтоол, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянтал сумын 4-р Цэцэрлэгийн дэргэдэх хүүхэд хамгааллын багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн дарга:

Б.Энхмэнд (4-р Цэцэрлэгийн эрхлэгч)

Гишүүд

Б.Золзаяа (Бүлгийн багш)

Н.Орхонтуул (Бүлгийн багш)

Б.Бархасжаргал (Бүлгийн багш)

Нарийн бичгийн дарга:

Э.Энхсайхан (Аж ахуй нярав)

2.4-р Цэцэрлэгийн орчинд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг хамгаалж, боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэхэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, журмын дагуу ажиллахыг комиссын дарга гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Нийгмийн бодлого, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Ч.Отгонцэцэг)-д даалгасугай.

ДАРГА

Г.АНХБАЯР